

ТӨРИЙН БАНКНЫ ОРОН НУТГИЙН ТООЦООНЫ ТӨВИЙН
БАРИЛГЫН ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

2020.03.30

1	Барилга байгууламжийн байршил	Увс салбар “Сагил” тооцооны төв	
2	Хүчин чадал: (бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний нэр төрлөөр)	Зориулалт	Банкны үйлчилгээний
		Хэмжээ	10,0м x 9,0м
		Давхрын тоо	1 давхар
3	Ажиллах горим	Ердийн	
4	Үйлдвэр, аж ахуйн газар, барилга байгууламжийн бүрэлдэхүүн	Банкны үйлчилгээний зориулалттай 1 давхар барилга	
5	Барилгын үндсэн бүтээц, материал	Суурь	Цутгамал төмөр бетон баганан суурь
		Хана	Блок, дулаалгатай металл хавтан
		Хучилт	Цутгамал төмөр бетон
		Гадна тохижилт	Өөрийн эзэмшлийн газрын хэмжээгээр 40см-ийн өндөртэй бетонсуурьтай, 1,2м-ийн өндөртэй профиль төмөр хашаа, явган зам, талбай, хашааны гадна автомашины нягтруулсан шороон зогсоол, явган зам талбай, гадна гэрэлтүүлэг, түлээ нүүрсний байр, стандартын шаардлага хангасан модон жорлонтой байна.
6	Инженерийн шугам, сүлжээ түүнийг хангах эх үүсвэр	Дулаан	Нам даралтын болон цахилгааны хосолмол зуух /зурагт заасан үзүүлэлтийг хангасан байх /
		Цахилгаан	Техникийн нөхцлийг үндэслэн хийсэн зургийн дагуу
7	Зураг төслийн баримт зохиох үе шат	Геологийн дүгнэлт, барилгын батлагдсан зургийг захиалагчаас авна.	
8	Захиалагч байгууллага	Төрийн банк	
9	Тавигдах шаардлагууд	Барилгын гадна хана дулаалгатай металл хавтан өнгөлгөөтэй байх бөгөөд хавтангийн өнгө, захиалагчаас өгөгдсөн өнгөний код, хуваалтын дагуу гүйцэтгэх;	
		Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн налуу шат, шатны бариул зэрэг нь барилгын норм дүрмийн шаардлагыг хангасан байх бөгөөд гадна хаалганы онгойлтыг налуу шатны чиглэлд тохируулан суурилуулах;	
		<ul style="list-style-type: none"> - Ажлын өрөөний хануудыг “Extra color” брендийн В1661 кодтой угаадаг лактай эмульс - Гүйлгээ заал, тамбур, зуух, шитний өрөөний хана эмульсны өнгөтэй ижил өнгийн тосон будаг - Теллерийн ажлын хэсэгт зурагт заасан хэмжээсийн дагуу паркетан шал - Гүйлгээ заалны шал нь банкны стандарт, өнгөний дагуу чулуун плита - Гонхны дотор шал нь хальтардаггүй чулуун плита - Гадна довжоо, налуу шат, шатны марш нь барзгар боржин чулуу тус тус байна. 	


		<ul style="list-style-type: none"> - Барилгын гадна даацын металл рамтай ганжуулсан шилэн хаалга иж бүрэн тоноглолын хамт, хаалганы цоож нь 2-оос дээш эргэлттэй байх; - Гонхны гаднах дулаалгатай хамгаалалтын листэн хаалга нь иж бүрэн тоноглолтой байхаас гадна хаалганд 2-оос дээш эргэлттэй 2 төрлийн цоожтой байх; - Барилгад 3 давхар шилтэй вакуман цонх суурилуулах; - Цонхонд хамгаалалтын төмөр решётка хийх <p>Барилгын гадна дулаан, цэвэр бохир усны шугамыг нэгдсэн шугаманд холбохоор төлөвлөж байгаатай холбогдуулан, барилгын сууринд дулаан, цэвэр, бохир усны шугамын нүх гаргах;</p> <p>Гадна дотор хяналтын камер, дохиолол хамгаалалтын тоног төхөөрөмжийн далд монтажийн ажлыг зургийн дагуу хийх бөгөөд дохиоллын тоног төхөөрөмжүүд нь захиалагчаас өгөгдсөн үзүүлэлтийг бүрэн хангасан байх;</p> <p>Гадна цахилгааны кабелийн ажлыг техникийн нөхцлийн дагуу хийгдсэн зургийн дагуу барилгын норм дүрмийн дагуу хийж гүйцэтгэх;</p> <p><i>Дизель моторыг цахилгааны нөөц тэжээлд /мотор нь банканд байгаа/ ашиглахаар төлөвлөж байгаа тул ерөнхий шитэнд рубильникийг зургийн дагуу холбох;</i></p> <p>Барилгын ажлын төсөвт өртөгт дараах нэмэлт зардлуудыг оруулж тооцно.</p> <ul style="list-style-type: none"> - Барилга угсралтын иж бүрэн ажил <i>/дотор тоног төхөөрөмжийн ил далд монтажийн ажлууд орсон/</i> - Гадна тохижилтын ажил <i>/ гадна хаашаа, авто болон явган зам талбай, ногоон байгууламж, гадна гэрэлтүүлэг, туслах байгууламж болох модон жорлон, нүүрсний амбаар барих /</i> - Гадна шугам сүлжээний зургийн үнэ болох 867.570 төгрөгийг, - Барилгыг байнгын ашиглалтанд оруулсанаар барилгын кадастрын гүйцэтгэлийн зургийг мэргэжлийн компаниар гүйцэтгүүлэх зардал - Орон нутгийн ГХХБГ-аас хийгдэх захиалагчийн хяналтын зардал - Геологийн судалгааны дүгнэлттэй сайтар танилцаж барилгын суурийг нээсэний дараа хөрсний дүгнэлттэй тохирч байгаа эсэхэд дүгнэлт гаргуулах зардал зэрэг болно.
10	Ажил гүйцэтгэх хугацаа	60 хоног


Санхүүжилтын график

Санхүүжилтийн үе шат	Санхүүжилтийн хувь	Гүйцэтгэх ажил	Барилга угсралтын ажлын гүйцэтгэл хувь / % /
1-р шат	Урьдчилгаа 30%	Барилгын угсралтын ажлын материалын татан авалт	30%
		Улаан шугам тавих, барилгын ажил эхлэх зөвшөөрөл авах	
		Газар шорооны ажил	
		Суурийн ажил	
2-р шат	30 хувь	1,2-р давхарын барилга угсралтын ажил	75%
		Барилгын дүүргэлт, дотор ханы угсралт, дотор заслын ажил, цахилгаан, холбоо дохиоллын далд монтажийн угсралт, дотор дулааны тоног төхөөрөмжийн угсралтын ажил	
3-р шат	25 хувь	Барилгын гадна заслын ажил	100%
		Гадна тохижилт	
		Ажлын комисс ажиллуулах	
4-р шат	10 хувь	Байнгын ашиглалтанд хүлээлгэн өгөх	
5-р шат	5 хувь	Улсын комиссын акт баталгаажсанаас хойш 1 жилийн дараа	

Тайлбар:

1. Барилга угсралтын ажлыг гүйцэтгэхдээ батлагдсан зургийн дагуу захиалагчийн болон авторын хяналтанд дор гүйцэтгэнэ.
2. Орон нутгийн ГХБХГазар, мэргэжлийн хяналтын байцаагч болон банкны салбар нэгжийн удирдлагуудтай тогтмол хамтран ажиллана.

Боловсруулсан: ЕҮХ-ийн инженер /гэрээт/  М.Өнөрцэцэг

Хянасан: ЕҮХ-ийн захирал  Н.Ганзориг